

С ХЭСЭГ: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ С11: СОЁЛЫН ӨВ

АГУУЛГА

11. СОЁЛЫН ӨВ	2
11.1 ТАНИЛЦУУЛГА	2
11.2 ХАМРАХ ХҮРЭЭ.....	2
11.2.1 Орон зайн хамрах хүрээ	2
11.2.2 Цаг хугацааны хамрах хүрээ	2
11.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	3
11.3.1 Төлөвлөлтийн аргаар нөлөөллийг бууруулах	3
11.3.2 Нөлөөллийн тойм	3
11.3.3 Археологийн дурсгалд учрах бодит гарз хохирол.....	4
11.3.4 Археологийн дурсгалд нөлөөлөх шууд бус нөлөөлөл	8
11.3.5 Соёлын дурсгалт газруудад урьдчилан тооцоолсон нөлөөлөл.....	9
11.3.6 Биет бус соёлын өвд нөлөөлөх нөлөөллүүд	10
11.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ	15

Зургийн жагсаалт

Зураг 11.1: Хөшөө дурсгал-02 /Гашуун Сухайт хүртэлх зам дагуу/ булшинд хийсэн малтлага	6
--	---

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 11.1: Соёлын өвийн нөлөөллийн үнэлгээний хураангуй.....	17
---	----

11. СОЁЛЫН ӨВ

11.1 ОРШИЛ

Төслийн үйл ажиллагааны улмаас биет болон биет бус соёлын өвд үзүүлэх нөлөөллийг багасгах, арилгах, бууруулах, хохиролгүй болгох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга замуудын талаар тайлангийн уг бүлэгт өгүүлнэ. Нөлөөллийн шинж байдал, хийгдэж буй болон хийхээр төлөвлөсөн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, нөлөөллийн зэрэглэл, нөлөөллийг багасгах арга хэмжээ авсны дараа үлдэх нөлөөллийн зэрэглэл гэх мэт үзүүлэлтүүдэд тулгуурлан нөлөөллийн үнэлгээг хийсэн.

Монгол Улсын Соёлын Өвийг Хамгаалах Тухай Хууль (2001), Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн Стандарт 8 - “Соёлын өв”, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Гүйцэтгэлийн Шаардлага 8 “Соёлын өв” зэрэгт тодорхойлсон соёлын биет болон биет бус өвүүдэд нөлөөллийн үнэлгээг хийсэн. Уг тайланд биет болон биет бус өвийг доорх байдлаар тодорхойлов. Үүнд:

- **Биет соёлын өв:** Археологи, палентологи, түүх, архитектур, шашин, гоо зүй болон соёлын бусад үнэ цэнэ бүхий онцгой, нөхөн үл сэргэгдэх эд өлгийн зүйлс, дурсгалт газар, бүтцүүд, байгалийн өвөрмөц тогтоцууд орно хэмээн тодорхойлсон байдаг.
- **Биет бус соёлын өв:** Соёлын мэдлэг, туршлага, төлөөлөл, мэдлэг, ур чадвар, шинэ санаа, уламжлалт аж ахуйг тусгасан амьдралын хэв маяг, нутгийн иргэд болон хувь хүмүүс зарим тохиолдолд өөрсдийн ёс заншил соёлын нэг хэсэг гэж үздэг материаллаг бус соёлын нөөц багтана.¹

Менежмент, түүний хяналт шинжилгээний талаар *D13: Соёлын Өвийн Менежментийн Төлөвлөгөө* бүлгээс харна уу.

11.2 ХАМРАХ ХҮРЭЭ

11.2.1 Орон зайн хамрах хүрээ

Ханбогд сумын нутаг дах биет өв, аймгийн хэмжээн дэх биет бус соёлын өвийн хүрээнд нөлөөллийн үнэлгээг хийв. Ханбогд суманд хийсэн биет өвийн нөлөөллийн үнэлгээнд төслийн шууд нөлөөлөлд өртөх газрууд мөн багтах ба тухайлбал Уурхайн Лицензит Талбай, Гүний Хоолойн цооног болон усан хангамжийн сүлжээ, нисэх онгоцны түр болон байнгын буудлууд, Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх зам тээврийн дэд бүтцүүд зэрэг орно.

Үйл ажиллагаа явагдахын хирээр төслийн дэд бүтэц өргөжин тэлж байгаатай холбогдуулан археологийн болон археологийн дурсгалд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг цаашид Монгол улсын Засгийн Газар, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи (МУ-ын ШУА)-ийн Археологийн Хүрээлэн болон Палентологийн төвийн шаардлагын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай болно. Сумын төвийг тэлж өргөжүүлэхтэй холбоотойгоор дэд бүтцийг хөгжүүлэхэд археологийн нэмэлт судалгаа явуулах шаардлага гарч ирэх бөгөөд цаашид барилгын бүтээн байгуулалтын ажлын үед “авран хамгаалах малтлагын” ажил голчлон хийгдэнэ. Дэд бүтцийг хөгжүүлэх ажлын хүрээнд Ханбогд ба Оюу Толгойн уурхайг холбосон эрчим хүчний шугам татах, ус дамжуулах (Гүний Хоолой, усан хангамжийн хоолой) хоолойг байгуулах, Ханбогд-Оюу Толгойн авто замыг сайжруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Бусад газруудын хувьд аливаа нэмэлт археологийн болон палентологийн судалгаа хийх шаардлагатай эсэхийг МУ-ын ШУА-ын Археологийн Хүрээлэн болон Палентологийн төв тодорхойлно.

11.2.2 Цаг хугацааны хамрах хүрээ

Үнэлгээний цаг хугацааны хамрах хүрээ нь барилгын ажлын, уурхайн олборлолтын, уурхайг хаалтын үе гэсэн үе шатуудыг хамарна.

¹ Олон улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ийн удирдамж тэмдэглэл: Нийгэм, Байгаль орчны тогтвортой байдлын Гүйцэтгэлийн Стандарт. Удирдаж тэмдэглэл 8 ‘Соёлын Өв, 2007 оны 7 сар. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ) Байгаль орчин, нийгмийн бодлого: Гүйцэтгэлийн шаардлага 8 ‘Соёлын Өв, 2008 оны 5 сар.

11.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

11.3.1 Төлөвлөлтийн аргаар нөлөөллийг бууруулах

Урьд нь хийгдсэн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (БОНБНУ)-үүдийн явцад төслийн төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн археологийн болон палентологийн өвд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох оролдлогуудыг хийж ирсэн. Төслийн хүрээнд барьж байгуулахаар төлөвлөгдсөн бүтцүүдийн байршил болон зам, ус дамжуулах хоолой зэрэг шулуун байгууламжийн загварт шаардлагатай үед өөрчлөлтүүдийг оруулсан. Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тоймлон үзүүлбэл:

- *Оюу Толгой-Гашуун Сухайтын авто замын шугамыг шинэчлэх:* Оюу Толгой-Гашуун Сухайтын хооронд тавих замын маршрутын дагуу хийсэн 2004 оны археологийн судалгаагаар чухал ач холбогдолтой археологийн олдворуудыг олж тогтоосон бөгөөд энэ нь замын маршрутыг шинэчлэн тогтооход хүргэсэн олон хүчин зүйлүүдийн нэг байсан юм. Шинэчлэн тогтоосон замын маршрутын дагуу дараа дараагийн судалгаануудыг 2006, 2010, 2011 онуудад тус тус хийсэн. 2010 оны судалгаагаар таван булш олж илрүүлсэн ба эдгээр булшинд 2011 оны эхээр Археологийн Хүрээлэн авран хамгаалах малтлага² хийсэн байна. Хамгийн сүүлийн судалгаагаар Оюу Толгой-Гашуун Сухайтын хоорондын зам тавих ажилд өртөж болох өөр дурсгалууд олдоогүй бөгөөд энэ нь аливаа нөлөөллүүдээс зайлсхийх боломжийг бүрдүүлнэ хэмээн үзжээ. (*В 12: Соёлын өв*” бүлгийг үзнэ үү).
- *Гүний Хоолойн ус дамжуулах хоолойн шугамыг тогтоох:* Гүний Хоолойн ус хуримтлуулах хоолой болон боловсруулах цоонуудын (OTS-1, OTS-2, OTS-3)³ ойролцоо нэлээд тооны булш байгаа болохыг тогтоосон. Үүний үр дүнд эдгээр булшнуудад хор нөлөө учруулахгүйгээр гол хоолойг суурилуулж, сүлжээнд холбосон. Уг олдсон дурсгал болох булшнуудаас гол хоолойд ойрхон байгаа гурвыг цаашид бүтээн байгуулалтын явцад хамгаалахын тулд хил зааг тогтоож, хашиж хамгаалах юм. (*В 12: Соёлын өв*” бүлгийг үзнэ үү).
- *Гүний Хоолойн ус дамжуулах хоолойн шугамыг тогтоох:* 2011 оны 11-р сард Палентологийн төвөөс хийсэн усны хоолойн палентологийн үнэлгээ болон хяналт шинжилгээгээр санал болгож буй *PB07-ийн дэд шугамын байршил нь өндөр мэдрэмтгий газар хэмээн тодорхойлогдсон. Үүний үр дүнд энэхүү дэд шугамын зурвасыг дахин тогтоосон бөгөөд бусад дэд шугамуудын зурвасыг өөрчлөөгүй.*

Нисэх онгоцны түр болон байнгын буудлуудыг барих газрын орчимд томоохон, ач холбогдол бүхий дурсгал илрээгүй тул археологийн эсвэл палентологийн ач холбогдолд үндэслэн боловсруулсан загварт өөрчлөлт хийгдээгүй байна.

11.3.2 Нөлөөллийн тойм

Төслийн бүтээн байгуулалт ид өрнөж буй энэ үед газар ухах, шимт хөрсийг хуулах, шинээр туслах зам тавих, нүх ухах зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор соёлын өвд үзүүлэх нөлөөллүүд олон хэлбэрээр илрээд байна. Бүтээн байгуулалт, олборлолтын шатанд илрээд байгаа болон соёлын өвд учирч болох нийт нөлөөллүүдийг доор жагсаавал:

- Оюу Толгой төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалттай холбоотойгоор газар ухах явцад соёлын биет өвүүдийг гэмтээх, материаллаг хохирол учруулах;
- Бүтээн байгуулалтын ажилд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгсэл, машин механизмын ашиглалт, техникийн үйл ажиллагаатай холбоотойгоор соёлын өв тоос шороонд дарагдах, дуу чимээ гэх мэт шууд бус нөлөөллүүд
- Төслийн ажилчид болон тухайн орон нутагт шилжин суурьшихаар ирж буй хүмүүс соёлын өвд аюул занал учруулах, санаатай эвдэж, сүйтгэх

² ШУА-ын Археологийн Хүрээлэн, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах “Оюу Толгой” төслийн гүйцэтгэлийн талбай. Бүтээн байгуулалтын ажил явуулснаас үүдэн гэмтэж болзошгүй дурсгалт газруудыг авран хамгаалах малтлагын тайлан, 2011 оны 3 сар.

³ ШУА-ын Археологийн Хүрээлэн, Усны хоолойн шугамыг тавихад хийсэн археологийн тайлан 2006

- Хийж буй ажлын онцлог, садан төрлийн холбоо, сүсэг бишрэл, орлогын эх үүсвэрийн өөрчлөлт зэрэгтэй холбоотойгоор цагийн эрхээр биет бус соёлын өв мартагдан устаж байна. Жишээ нь: малчид цалинтай ажил хөдөлмөр эрхэлж эхэлснээр уламжлалт аж ахуй, амьдралын хэв маягаа орхиж байна.

Барилгын ажлын үе шаттай харьцуулахад үйл ажиллагааны үе шатанд газар шороо болон инженерийн нэмэлт үйл ажиллагааны цар хүрээ харьцангуй хязгаарлагдмал байх тул археологи, палеонтологийн дурсгалт газруудыг гэмтээж, сүйтгэх явдал багасах учиртай. Үүний адилаар уурхайн хаалтын үе шатанд газрын томоохон эвдрэл үүсэхгүй тул нөлөөлөл үүсэх магадлал багатай боловч газрын гадаргууг тэгшлэх, нөхөн сэргээлт хийх зэрэг хөрс шороотой холбоотой зарим үйл ажиллагаанууд биет соёлын өвд бага хэмжээний нөлөөлөл учруулах магадлалтай юм. Гэсэн хэдий ч эдгээр үйл ажиллагаануудын улмаас ноцтой, томоохон нөлөөллүүд үүсэхгүй хэмээн таамаглаж байна. Учир нь эдгээр үйл ажиллагаанууд өмнө нөлөөллийн үнэлгээ хийсэн газруудад хийгдэх юм. Харин зан заншил болон уламжлалт амьдралын хэв маягт гарах урьдчилан таамагласан өөрчлөлтүүд нь урт хугацааны нөлөөллүүдийг учруулж болзошгүй юм.

Энэхүү бүлгийн төгсгөлд үүсч болох эерэг болон сөрөг нөлөөллүүдийг хүснэгтээр тоймлон үзүүлсэн. Үүссэн гол нөлөөллүүдийг доор тодорхойлон бичлээ.

11.3.3 Археологийн дурсгалд учрах бодит гарз хохирол

Нөлөөллийн тодорхойлолт

2002 оноос хойш хөрс цэвэрлэх, ашигт малтмал олборлох болон бүтээн байгуулах зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр алт, зэс олдворууд, хадны сүг зураг, чулуун байгууламж, үлэг гүрвэлийн чулуужсан өндөг, оршуулгын газрууд зэрэг археологийн болон палентологийн олон тооны дурсгалуудад малтлага хийх, зөөвөрлөх зайлшгүй шаардлагатай болсон.

Барилгын ажлын үе шатанд археологийн болон палентологийн дурсгалуудад малтлага хийх нь эртний зэсийн орд зэрэг үндэсний ач холбогдол бүхий газруудад учруулах нөлөөллүүдийг улам бүр нэмэгдүүлж байна. Тухайлбал, Үрлүбэ үндэсний палентологийн бүсэд эртний зэсийн уурхай болон чулуужсан үлдэгдлийн олдвор олдож байна. Ундай голын голдирылыг өөрчилснөөр далангаас Хүрэн Толгой хүрэх Ундай голын 6.8 км урт голдирылд (Ундай голын салаа) үерийн үед ус хальж урсахгүй бөгөөд газрын доорх усны урсгал ч мөн адил халихгүй ба Бор Овоогийн булаг болон овоо устаж алга болохгүй. Энэхүү 6.8км урт голын салаа хэсгийн ихэнх нь (90%-аас их) хаягдал чулуулгийн овоолго (ХЧО) барих үед болон ил уурхайн барилгын ажил, тээврийн замын үйл ажиллагааны улмаас устах юм (Бор Овоо Булгийн зарим хэсэг мөн устана). Ундай голын салааны богино урсац ХЧО-ын доод хэсэгт үлдэх бөгөөд энэ хэсэгт Хүрэн Толгойн орчмоос өөрчилсөн голдирылын ус нийлж Ундай голын урсацыг сэргээх болно. Ундай голын уг богино салаа нь аллювийн хурдасын гүний усаар тэжээгдэх шинэ булгийн орчимд оршино. (*Нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ хэсгийг харна уу*).

В12: Соёлын Өв бүлэгт тодорхойлсноор: “*Оюу Толгойн Соёлын Өвийн Хөтөлбөрийн 1 дүгээр шат болох Соёлын өвийн тухай бүлэгт төслийн бүтээн байгуулалтын өмнөх болон бүтээн байгуулалтын үеэр олж илрүүлсэн археологийн болон палентологийн дурсгалуудын үнэ цэнэ, ач холбогдлын үнэлгээ багтсан байна. Үнэлгээг Монгол Олон Улсын Өвийн Баг (МОУӨБ) хийж гүйцэтгэсэн. Эдгээр дурсгалт газрууд нь Монгол Улсын хуулийн дагуу албан ёсоор бүртгэгдээгүй хэдий ч үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байсан.*

МОУӨБ-ын үзэж байгаагаар булш, оршуулга зэрэг нөлөөлөлд өртсөн дурсгалт газруудыг “ердийн” гэж үзэх бөгөөд 13 дугаар зуунаас хойших үеийн гэх дурсгалууд олдоогүй байна. (жишээ нь, одоогийн оршин суугч хүн амтай аливаа нэгэн хамаарал байхгүй). Хэдийгээр үлэг гүрвэлийн өндөг нь говьд нийтлэг байдаг ч палентологи судлалын үүднээс олон улсын хэмжээнд анхаарал татдаг учраас түүнийг цаашид судлах зорилгоор Улаанбаатар хотод хадгалж байна. Оршуулгын чулуун байгууламжуудад (амьтны тахил өргөлийн газар) хүний ул мөр олдоогүй ба тэдгээрийг ердийн гэсэн зэрэглэлд оруулсан байна.

Палентологийн төвөөс Гүний Хоолойн усны хангамжийн шугамын дагуу нөлөөлөлд өртсөн талбайг тодорхойлж авран уг талбайг “чухал” хэмээн үзсэн. Гэсэн хэдий ч энэхүү газруудад барилгын ажил хийгдэж байна.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Оюу Толгой төсөл нь доор танилцуулах арга хэмжээгээр дамжуулан соёлын өвийн дурсгалыг хамгаалах үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлж байна.

Авран хамгаалах малтлага

Өнөөг хүртэл авч хэрэгжүүлж ирсэн нөлөөллийг бууруулах үндсэн арга хэмжээ нь археологийн сан хөмрөгийн бүртгэл болон малтлага юм. Түүхийн болон сүүлийн үеийн малтлагын хураангуй тайлбарыг доор танилцуулбал:

- Уурхайн ашиглалтын талбайгаас 18 ба 19 дүгээр зуунд хамааралтай зэс боловсруулж байсан эртний 4 газрыг олж илрүүлж, олборлох болон ухах зориулалт бүхий чулуун багаж хэрэгсэл, амьтны яс, мөн бусад эд өлгийн зүйлсийг малтан гаргаж, Улаанбаатар хотод байрлах ШУА-ын Археологийн Хүрээлэнд хүргүүлсэн;
- Түүнчлэн уурхайн ашиглалтын талбайгаас хоёр чулуун байгууламжийг илрүүлж, холбогдох эд өлгийн зүйлсийг Улаанбаатарт хүргүүлсэн;
- 2005 онд 1-р босоо амны малтлагын үеэр олж илрүүлсэн үлэг гүрвэлийн чулуужсан 23 өндөгийг мөн малтан гаргаж, Монгол Улсын Их сургуульд хүргүүлсэн;
- 2011 оны 2-3 дугаар сард ШУА-ын Археологийн Хүрээлэнгийн баг (Улаанбаатар Дээд сургууль, Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн төлөөлөл багтсан) Оюу Толгойгоос Ханбогд хүртэлх, Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх зам болон цахилгаан дамжуулах шугамтай⁴ ойр орших 17 археологийн дурсгалд малтлага хийсэн. Эхний шатанд хүрэл зэвсгийн үед хамаарагдах (МЭӨ III – МЭ II зуун) булшнууд болон чулуун байгууламжууд, Хүннү гүрний нээлттэй суурин (МЭӨ III- МЭ II зуун) болон Түрэгийн үеийн (МЭ VI зуун) зэл чулуу бүхий байгууламжид малтлага хийсэн. Цахилгаан дамжуулах шугам болон Гашуун Сухайтын зам дагуу гол төлөв булшнууд олдсон бөгөөд тэдний заримаас хүний ул мөр олдсон (Зураг 11.1)
- OTW-01 талбайгаас нийт 120 ваарны хагархай олдсон ба үүний дараа малтлагын талбайн гадна байсан 28 ваарны хагархайг нэмж бүртгэсэн байна. OTW-02 талбайгаас Ханбогд сумын төвөөс урагш өмнөд ууланд байрлах (Ханбогд сумаас урагш 4 км) зэл чулуу бүхий газруудыг хамарсан. OTW-02 талбайд нийт 30 зэл чулуу бүхий газрыг олж тогтоосон. OTW-03 талбай нь Ханбогд сумаас 5 км зайд байх шороон замаас хойш орших орой дээрээ овоотой хоёр жижиг толгодыг хамарна. Монгол нутагт олдсон бусад дурсгалт газруудтай эдгээр газрууд ижил төстэй байсан тул МОУӨБ 'ердийн' өв хэмээн тодорхойлсон.

2011 оны 11-р сараас 2012 оны 6-р сар хүртэл Палентологийн төвийн баг Гүний Хоолойн усны хангамжийн шугамын дагуу хянаж талбайд малталт хийсэн. Хяналт шинжилгээний ажлыг 2011 оны 11-р сарын 1-нээс 12-р сарын 15-ны хооронд хийсэн бөгөөд дахин 2012 оны 5-р сарын 20-ноос 5-р сарын 30-ны хооронд явуулсан. Хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүнд СТР#1 талбайн РВ02, РВ04, РВ05, РВ06 болон РВ07 хэсгүүдэд 2011 оны 12-р сарын 15-наас 2012 оны 5-р сарын 30 –ны хооронд малталт хийсэн. Малталтын үр дүнд бүрэн бус, саланги яс олдсон бөгөөд эдгээр нь олдворын шинжлэх ухааны ач холбогдлоороо ховор олдворт тооцогдоно.

ГХ 01 дэхь ус шахах цэгээс хоолойн шугам болон холбогдох гүний өрөмдлөгийн худгийн судалгаанаас харахад гүний цооногийн оглолцолын хэсгийг нь палентологийн илэрцтэй газар хэмээн хил тогтоосон. Гүний Хоолойн цооног дахь худгууд нь Монгол улсын засгийн газрын 2008 оны 175-р тушаалаар соёлын болон түүхийн ач холбогдол бүхий хөдөлгөж үл болох хамгаалагдсан хөшөө хэмээн тодорхойлогдсон Үрүлбэ үндэсний палентологийн бүсэд нэвтэрсэн тул чулуужсан үлдэгдлийг сэндийлэхээс зайлсхийхийн тулд ГХ01 ус шахах дамжуулах цэгээс худаг хүртэлх

⁴ Эдгээр 17 зүйлсийн зургааг нь Херуга талбайгаас малтаж гаргасан.

зарим сувгийн зурвасыг өөрчлөх талаар зөвлөмжийг гаргасан юм. ГХ01 ус шахаж дамжуулах цэгийн ойролцоох газар хийсэн палентологийн нарийвчилсан хяналт шинжилгээгээр палентологийн ач холбогдлоор нь энэхүү хэсгийн газрыг “чухал” болон “хамгийн эмзэг мэдрэмтгий газар” хэмээн ангилсан бөгөөд малталтыг “чухал” хэмээн ангилалын газар хийхдээ жижигхэн багаж төхөрөмжөөр хийхийг зөвлөмж болгосон. “Хамгийн эмзэг мэдрэмтгий” газар малталтыг хийхгүй. Зөвлөмжийн хүрээнд нөлөөллийн бүсийг тодохойлж палентологийн малталтыг худгийн шугам хоолой сууриулсаны дараа хийх, худгийг цаашид засварлах явцад гарах чулуужсан үлдэгдэл гэмтэхээс сэргийлж урьтан авах ёстой.

Зураг 11.1: Дурсгал-02 /Гашуун Сухайт хүртэлх зам дагуу/ булшинд хийсэн малтлага



Зэс боловсруулах газрын түүхэн онцлогийг судлан үзэж, тэрхүү уурхайг гүнд нь хүртэл судлах, Ханбогд сумын музейд уг уурхайн загварыг бүтээж тавих зэрэг нэмэлт ажлуудыг ШУА-ын Археологийн Хүрээлэн хийсэн. Түүхийн хүрээлэн угсаатны зүйн үнэлгээ болон аман түүхийг баримтжуулах ажлыг хийсэн. Оюу Толгой нь Ханбогд сумын музейн үзмэрийг харуулах загварыг бий болгох ажлыг төлөвлөж байгаа бөгөөд 2013 оны төгсгөл гэхэд 3Д-ээр музейн үзмэрийг үзэх боломжтой болно. Оюу Толгой түүнийг бүтээн босгох хамгийн тохиромжтой хэлбэрийг тодохойлохын тулд ШУА-ын Археологийн Хүрээлэнтэй хамтран ажиллах зорилт тавиад байна.

Дээр танилцуулсан малтлагуудын үр дүнд Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтын явцад биет соёлын өвийн дурсгалуудыг олж илрүүлэн хадгалж, хамгаалж байна. Дурсгалуудыг судлах, зурагжуулан баримтжуулах болон Монголын холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Соёлын Өвийн Хөтөлбөр (СӨХ)

Соёлын өвийн дурсгалт газруудад учрах гарз хохирлыг багасгах арга хэмжээ нь дээр өгүүлсэнчлэн археологийн болон палентологийн олдворуудыг баримтжуулах, бүртгэх, малтах, хадгалж хамгаалах зэрэг байдлаар аль хэдийнэ хэрэгжиж эхлээд байна. Оюу Толгой төслөөс олон нийтэд өгөх соёлын үр шим хэмээн үзсэний үндсэн дээр СӨХ-ийн эхний үе шатанд аймгийг бүхэлд нь хамарсан соёлын биет болон биет бус өвийг хамруулан дурсгал, өвийг баримтжуулах ажлууд хийгдсэн. Эхний шатны урьдчилсан тайланг 2011 оны 2 дугаар сард Оюу Толгой болон МОУӨБ бэлтгэн гаргасан бөгөөд Оюу Толгойн цахим хуудсанд тавигдсан уг тайланг Ханбогд сумын иргэд танилцах бүрэн боломжтой. Эцэст нь 1 дүгээр шатны ажилд атус аймгийн археологийн нөөцийн өргөн хүрээний зураглал болон газар зүйн мэдээллийн сан орсон. Уг талбайн мэдээллийн

мэдрэмтгий байдлаас шалтгаалан энэхүү мэдээлэл нь холбогдох байгууллагуудад зөвхөн бий. Энэхүү тайлан нь аймгийн өвийн талаарх иж бүрэн тайлан мэдээг багтаах болно.

Төслийн 2-р үе шатанд хийгдэх үйл ажиллагааны үр дүн мөн олон нийтэд нээлттэй байна.

Газар хөндөх зөвшөөрөл

Урьд нь ашиглагдаж байгаагүй талбайд малтлага, олборлолт хийхээр төлөвлөсөн тохиолдолд ШУА-ын Археологийн Хүрээлэнд урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд газар хөндөх зөвшөөрөл авна. Ил уурхайд малтлага хийх нь хамгийн томоохон шууд хохирол, нөлөөллийг учруулах бөгөөд цэрдийн шаварлаг давхрагад малтлага хийснээр палеонтологийн олдворуудыг гэмтээх аюултай болохыг Оюу Толгой компани сайтар ухамсарладаг.

Булгийг сэргээх

Шинээр булаг барих хамгийн тохиромжтой байрлалыг тодорхойлсон даруйд Бор Овоо булаг болон овоог орлох булаг болон овоо барих ажлыг доорх дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Нутгийн ахмад настнууд болон лам нарын тусламжтайгаар булаг барихад тохиромжтой байрлалыг тодорхойлох;
- Шинэ тодорхойлсон байрлалд лам нараар ном уншуулж, овоо босгох. Холбогдох зан үйлийг гүйцэтгэх. Жишээлбэл газар хөндөхөөс өмнө гараараа эсвэл модоор газар дээр гахайн зураг зурах, мөн гахайн соёогоор эхлээд газар хөндөж, хүн биш гахай газар сэндийчиж буй мэтээр газар усаа аргадах олон төрлийн зан үйлийг нутгийнхан хийдэг;
- Газар ариутгах зан үйлийг гүйцэтгэж, ном уншуулах;
- Булгийг байгуулж дууссаны дараа дахин газар, лус аргадсан ном уншуулах;
- Овоог залах хүнийг сонгох;
- Овоог нүүлгэсний дараа ламар ном уншуулан овооны савдаг эзэн дуудах.

Тохиолдлын Олдворын Журам

Ил уурхайн ашиглалт болон бусад малтлагууд зэрэг газар ухах, малтах үйл ажиллагаа явагдах бүх газруудад нөлөөллийг бууруулах үндсэн үйл ажиллагаа нь *Тохиолдлын олдворын журмын* хүрээнд хэрэгжинэ. *Тохиолдлын олдворын журмыг*⁵ Оюу Толгой компани нь Рио Тинто компани болон соёлын өвийн зөвлөхүүдтэй зөвшилцөн, санаачилсан. Энэхүү журмыг археологи, палеонтологийн дурсгал зэрэг соёлын буюу түүхийн ач холбогдол бүхий урьд өмнө нь баримтжуулагдаагүй аливаа эд зүйлсийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал болон тэдний зөв зохистой ашиглалт, хадгалалтыг хангах үүднээс боловсруулан гаргасан. Уг журмыг Оюу Толгойн бүх ажилчид болон гэрээлэгчид дагаж мөрдөх шаардлагатай.⁶ *Тохиолдлын олдворын журмын талаар D13: Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө* бүлэгт нарийвчлан тусгасан.

Нөлөөллийн зэрэглэл

Биет соёлын өвийн дурсгал орших газруудад малтлага хийх нь төслийн явцаас харагдаж байгаагчлан байнгын (**урт хугацааны**) нөлөөллүүдийг үүсгэнэ. Эдгээр нөлөөллүүд өмнө нь үүсч байсан төдийгүй археологи, палеонтологийн зарим дурсгалууд үндэсний болон олон улсын хэмжээнд **чухал ач холбогдолтой** байдаг тул томоохон нөлөөлөл, хохирлыг учруулах **эрсдэлтэй**. Дээр тодорхойлсноор малтлагын арга хэмжээ нь археологийн болон палентологийн дурсгалд үзүүлэх бодит хохирлыг нөлөөллийг бууруулах болон өргөн хүрээний авран хамгаалах малтлага хийх зэргээр аливаа зүйлийг хадгалж хамгаалахад чиглэгдэнэ. СӨХ-ийн 2 дугаар шатны үйл

⁵ *Тохиолдлын олдворын журам* нь Оюу Толгой төслийн Соёлын өвийн хөтөлбөрийн 1 дүгээр шатны тайланд Хавсралт 5-д бүрэн эхээрээ орсон бөгөөд энэхүү БОННУ-ний D13:Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө бүлэгт нэмэлтээр орсон.

⁶ *Тохиолдлын олдворын журам* нь газар шорооны ажилд оролцсон хүн болгонд хамаараалтай (малтлага, ухалт, өрөмдөлт гэх зэргийг хийж байгаа ажилчид, гэрээлэгч болон дэд гэрээлэгч).

ажиллагааны хүрээнд газар хөндөх зөвшөөрлийн тогтолцоог мөрдөн хэрэгжүүлэх, Оюу Толгойгоос олдсон зэс эд зүйлсийн хуулбарыг хийх зэрэг нөлөөллийг багасгах дараа дараачийн арга хэмжээнүүд хийгдэж байна. Нөлөөллийг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа гарах үр дагаварын хэмжээг олдворуудын онцлог шинж чанараас хамааран **бага хэмжээтэй** хэмээн тодорхойлсон. Бор Овоо булгийг шилжүүлсэн нь **орон нутгийн чанартай, байнгын** нөлөөлөл үүсгэх хэдий ч овоог шилжүүлж, булгийг шинээр барьснаар **үлдэх нөлөөлөлийг багасгах** нөхцөл бүрдэнэ.

11.3.4 Биет соёлын өвийн нөөцийн шууд бус нөлөөлөл

Нөлөөллийн тодорхойлолт

Барилгын тоног төхөөрөмж, машин техникийн ашиглалт, зам болон дэд бүтцийг барьж байгуулах, машин техникийн хөдөлгөөн зэрэг нь археологи, палеонтологийн дурсгалт газруудад шууд бус нөлөөллийг учруулах аюултай. Түүнчлэн тусгайлан төслийн зориулалтаар ашиглагдахаар заасан замаас гадуур буюу биет соёлын өвийн дурсгалуудтай газар нутгаар тээврийн хэрэгсэл зорчих нь сөрөг нөлөөллүүдийг үүсгэнэ.

Төслийн нөлөөллийн бүс доторх замуудыг засаж, шинэчлэх, шинэ зам тавих зэрэг нь төдийлөн амар хүрэх боломжгүй байсан дурсгалуудад (овоо, суврага г.м) хялбар очих нөхцлийг бүрдүүлнэ. Үүний улмаас аливаа дурсгал соёлын өв хууль бус худалдаалагчдын гарт очих хоёрдогч нөлөөллүүдийг үүсгэх аюултай.

Дээрх нөлөөллүүдийн зэрэгцээ нөлөөллийн үр дагаврын цар хүрээ нь дурсгалын үнэ цэнэ, ач холбогдлын талаарх шинжээчийн гаргасан тодорхойлолт болон нутгийн иргэдийн хандлагаас хамаарна. *B12: Соёлын өв* бүлэгт тодорхойлсноор: Өмнөговь аймаг нь олон тооны хадны сүг зураг, овоо, тахилгын газар, мөн тэдэнтэй холбоотой уламжлал, зан үйл зэрэг биет болон биет бус соёлын өвөөр баялаг нутаг бөгөөд үүсч болох нөлөөлөл нь дурсгал бүрийн хувьд харилцан адилгүй байна.

Нөлөөллийг багасгах арга хэмжээ

Зам тээврийн менежментийн төлөвлөгөө

Тээврийн хэрэгслийг жолоодох арга техник, тоосны дэгдэлтийг хянах болон замын маршрутыг тогтоох зэрэг үйл ажиллагаа нь хурдны зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлон хянах, төслийн хүрээнд гэрээт гүйцэтгэгч болон давхар гэрээт гүйцэтгэгчдийн ашиглаж буй машин, тээврийн хэрэгслийн зорчих замын чиглэлийг тогтоох чиг үүрэг бүхий замын хөдөлгөөний удирдлагын нарийн схемээр зохицуулагдана. Оюу Толгойн замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө нь эдгээр дүрэм журмын хэрэгжилтийг хянаж, шалгах нөхцөлүүдийг нарийвчлан тогтоох үүрэгтэй. (жишээ нь, замын хуудас, жолоочийн замд гарахын өмнөх, замд явж байх үеийн болон замаас ирсний дараах тайлан, хурдны хяналт, холын замд явах).

Гэрээт гүйцэтгэгчид археологийн болон палентологийн ач холбогдол бүхий газруудаар зорчихгүй байх болон тэдгээрийг хайрлаж, хамгаалах (жишээ нь, ус дамжуулах хоолойн ойролцоох булш) үүрэгтэй. Төслийн зам тээвэртэй хамааралтай ажилладаг бүх боловсон хүчин⁷ төдийгүй түүний гэрээт гүйцэтгэгч болон давхар гэрээт гүйцэтгэгч байгууллагуудын холбогдох хүмүүс замын хөдөлгөөний удирдлагын сургалтанд заавал хамрагдана.

Кэмпид биеэ авч явах байдал, харьцааны соёл

Оюу Толгой нь өөрийн ажилчдын ажилд ирэх, явах цагийг бүртгэх журам, сумын төвд ажиллах удирдамж зэргийг багтаасан *Кэмпид биеэ зөв авч явах байдал, харьцааны соёл (D17: Хөдөлмөр эрхлэлтийн менежментийн төлөвлөгөөг үзнэ үү)*-ын бодлогын хүрээнд хатуу чанд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Ажилчдыг тогтмол сургалтанд хамруулж, холбогдох байцаагч нар

⁷ Энэхүү асуудлыг танилцуулга болон сургалтын үеэр бүх гэрээт гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч танилцуулна.

тогтмол хяналт, шалгалт тавьж, зөрчил маргаан үүссэн тохиолдолд болон Төслийн санал гомдол хүлээн авах механизмийн хүрээнд ирсэн санал гомдлыг судалж, сахилга батыг сахих арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар харьцааны соёлын бодлогыг мөрдөн ажиллана. Санал гомдол хүлээн авах механизмийн талаар *D17: Хөдөлмөр эрхлэлтийн Менежментийн төлөвлөгөө* бүлэгт танилцуулна.

Соёлын мэдлэгийг дээшлүүлэх сургалт болон олон нийтийг татан оролцуулах

Оюу Толгойн бүх ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдийг “Тохиолдлын олдворын журам”-ын хүрээнд зохих сургалтад хамруулж, соёлын өвийг хамгаалах хуулийн мэдлэг олгодог. Соёлын өвийн дурсгалт зүйлсийг таньж илрүүлэх болон уг журмыг мөрдөн ажиллахтай холбоотой тусгай сургалтыг газар ухах болон бусад холбогдох үйл ажиллагаанд оролцдог болон удирдан ажиллах Оюу Толгойн ажилчид, ахлагч нар, төдийгүй Оюу Толгойн нийт хамт олон, байгаль орчны байцаагч нарт зохион байгуулна.

Нөлөөллийн зэрэглэл

Биет соёлын өвийн дурсгалт газруудад учрах шууд болон шууд бус нөлөөлөл нь бүтээн байгуулалтын ажлын үеэр төдийгүй үйлдвэрлэлийн үе шат болон уурхайн хаалтын үйл ажиллагааны үеэр ч илэрч болох тул **урт хугацааны** эрсдлийг дагуулна. Үүсэх нөлөөлөл нь аймгийн хүрээнээс гадуур соёлын болон түүхийн үнэт зүйлд нөлөөлөлөхгүй хэмээн таамаглаж байгаа тул нөлөөллийн тархах хүрээг **хязгаарлагдмал** гэж тодорхойлж болно. Нөлөөлөл нь бүтээн байгуулалт болон зам тээврийн дэд бүтцийн хөгжлөөс **голчлон хамаарна**. Нөлөөллийг бууруулах дээр тодорхойлсон арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлсэн ба шууд ба шууд бус нөлөөллөөс гарах үр дагавар **бага хэмжээтэй** байна.

11.3.5 Соёлын дурсгалт газруудад үүсэх урьдчилан тооцоолсон нөлөөлөл

Нөлөөллийг тодорхойлох

Шүтлэгтэй, ариун дагшин (суврага, овоо болон байгалийн бүтээлүүд гэх мэт) газар нутгууд, тэдгээрт холбогдох уламжлалт зан үйлүүд нь Монголын соёлын өвийн чухал хэсгийг бүрдүүлдэг. Хэдийгээр тэдгээр ариун дагшин газрууд болон төслийн үйл ажиллагааны хооронд шууд хамаарал байхгүй ч цаашид тэдгээрт нөлөөлж болзошгүй юм. Шинээр шилжин ирж байгаа хүмүүс дурсгалт газрууд дээр тогтоосон тусгай хамгаалалтыг төдийлөн мэдэхгүйгээс, эсвэл тэдний санамсаргүй үйлдэл нь нутгийн иргэдийн санаа сэтгэлийг үймүүлэх, нутгийн иргэд болон гаднаас ирэгсдийн хооронд зөрчил маргаан үүсэх зэрэг санамсаргүй сөрөг нөлөө гарч болох талтай.

B12: Соёлын Өв бүлэгт тэмдэглэсэнээр: ШУА-ын Археологийн Хүрээлэнгээс явуулсан судалгаагаар Оюу Толгой төслийн бүсийн ойр орчмын уул толгодоор олон тооны хадны сүг зургийг олж илрүүлээд байгаа бөгөөд Жавхлант ууланд (Уурхайн Лицензит Талбайгаас баруун урагш 17 км) илүү анхаарал хандуулж байна.

Хэлэлцүүлэг хийх хөтөлбөрийн явцад ард иргэдийн санааг зовоосон нэг асуудал бол Жавхлант Хайрхан уулын эртний хадны бичээст нүүрлээд байгаа аюул бөгөөд шүтлэгтэй газрын утга учрыг нь алдагдуулах аюул занал учруулж болзошгүй гэж нутгийн иргэд үзэж байсан. Гаднаас ирсэн иргэд (уурхайн ажилчид, гадаадын иргэд, эсвэл бусад сумын иргэд эсэх нь тодорхой бус) Жавхлант уулын хадны бичээсийг гэмтээж, чулуужсан мод болон үнэт чулуунуудыг нь эвдэж сүйтгээд байна гэсэн аман болон баримтат нотолгоонууд байна. Хэдийгээр Оюу Толгой төслөөс үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй ч бүтээн байгуулалтанд ажиллах ажилчдын тоо нэмэгдэж байгаа нь тухайн газарт аюул учруулж болзошгүй бөгөөд Оюу Толгой төслийн ажилчидтай холбоотой үүсч болох аюулын эрсдлийг урьдчилан тогтоож, арилгах арга хэмжээ авах ёстой хэмээн нутгийн иргэд үзэж байна⁸. Шүтлэгтэй газар, байгалийн үзэсгэлэнт газар, уул овоонууд нь төслийн ажилчид болон гаднаас шинээр ирэгсдийн мэдлэг дутмаг, санаатай болон санамсаргүй үйлдлээс үүдэлтэйгээр эрсдэлд өртөх магадлалтай байж болох юм.

⁸ Оюу Толгой төсөл: Нийгмийн нөлөөллөх байдлын үнэлгээ (ННБУ), 2009.

СӨХ-ийн эхний шатны тайланд⁹ улсын үнэт дурсгалыг хууль бусаар малтаж, зарим талууд том хэмжээний малтлага явуулж, улмаар соёлын үнэт өвийг хууль бусаар хил давуулан худалдаалах зэрэг хууль бус ажиллагаанууд үйлдэгдэж байгаа талаар мэдээлжээ. Үүний уршгаар ашиг хонжоо хайгч болон соёлын зүйлсийг худалдаалагч этгээдүүд дутуу малтлага явуулж, үнэлж болшгүй чухал эд зүйлсийг эвдэлж, сүйтгэж байна.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Кемп дээр биеэ зөв авч явах ба харьцааны соёл

Кемп дээр биеэ зөв авч явах болон соёлтой харьцах бодлогын хүрээнд Оюу Толгой өөрийн ажилчиддаа хатуу хяналт тавин ажиллах болно. Төслийн нөлөөллийн газар нутагт байрлах өвийн газруудад хууль бус малтлага хийхэд хяналт тавьж, түүнчлэн, хэдийгээр Оюу Толгойн эрх мэдлийн хүрээнд хамрах асуудал биш хэдий ч захиргааны болон шийтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх болно. Төсөл нь санал гомдол хүлээн авах болон тайлагнах арга хэмжээнийхээ хүрээнд Төслийн газар нутагт хууль бусаар газар доогуур судалгаа болон малтлага хийх аливаа үйл ажиллагаануудыг олж илрүүлэхэд засгийн газрын холбогдох газрууд, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах болно. Зөвшөөрөлгүй малтлага хийх болон археологийн дурсгалт үнэт зүйлсийг дамжуулах, худалдаалах зэрэгт зөөлөн шийтгэл, торгууль ногдуулдаг албан ёсны туршлага нь энэхүү үйлдлийг таслан зогсоох, сэргийлэх хангалттай арга хэмжээ болж чадахгүй байна.

Оюу Толгойн бүх ажилчид, гэрээлэгчдэд археологи болон палеонтологийн дурсгалт зүйлсийг хайх, малтах, дамжуулах, худалдаалах зэрэг хууль бус олборлох, малтах аливаа хэлбэрийн үйл ажиллагааг санаачилах, оролцох явдлыг хориглоно. Ямарваа нэгэн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлөөс хамааран нэн даруй албан тушаалаас нь огцруулах, ажлаас халах шийтгэлүүдийг ногдуулна. Археологи эсвэл палеонтологийн эртний дурсгалыг хууль бусаар худалдаалах зэрэг онц ноцтой хэрэг үйлдсэн, оролцсон нь нотлогдвол Оюу Толгойн аливаа ажилтан болон гэрээлэгчийг ажлаас нэн даруй халж, холбогдох гэмт хэргийн болон иргэний хуулийн байгууллагад шилжүүлэх болно.

Соёлын мэдлэгийг дээшлүүлэх сургалт ба гадны зочдод танилцуулга хийх

Оюу Толгойн бүх ажилчид болон гэрээлэгчдийг “Тохиолдлын олдворын журам”-ын дагуу холбогдох сургалтанд хамруулж, соёлын өвийг хамгаалах хуулийн мэдлэг, мэдээлэл олгодог. Соёлын өвийн дурсгалт зүйлсийг таниж мэдэх болон тухайн журмыг мөрдөн ажиллахтай холбоотой тусгай сургалтыг газар ухах болон бусад холбогдох үйл ажиллагаанд оролцдог болон удирдан ажилладаг Оюу Толгойн ажилчид, хэлтсийн ахлагчид, төдийгүй Оюу Толгойн нийт хамт олон, байгаль орчны байцаагч нарт зохион байгуулна.

Нөлөөллийн зэрэглэл

Бүтээн байгуулалт, олборлолт болон уурхайг чөлөөлөх аль ч үе шатанд урьдчилан тогтоогдсон үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх нөлөөллүүдийг **урт хугацааны** болон **өргөн хүрээг** хамарсан хэмээн тодорхойлж болно. Бүтээн байгуулалт, зам тээвэр, дэд бүтцийн хөгжил, бүтээн байгуулалтанд оролцох ажилчдын хэмжээ болон төслийн газар нутагт ирэх оршин суугчдын тооноос **хамааран үүсэх нөлөөллийн** хамрах хүрээг тогтооно. Хэдий тийм ч дээр дурдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр энэхүү нөлөөллийн үр дагавар **бага** байх болно хэмээн урьдчилан тооцоолоод байна.

11.3.6 Биет бус соёлын өвд нөлөөлөх нөлөөллүүд

Нөлөөллийн тодорхойлолт

⁹ Өнгөрснөө хамгаалж, өнөөг хадгалъя. Оюу Толгой СӨХ-ийн 1-р шатны тайлан. Тайланг Састэйнабилити Ийст Эйжия ХХК, ШУА-ийн Археологийн Хүрээлэн хамтран бэлтгэсэн (2011 оны 2-р сар), 3.4-р хэсэг: Монгол улс дах дурсгалуудад учрах аюул занал хэсгийг харна уу.

Оюу Толгой төслийн хэрэгжилтийн үед биет бус соёлын өвд дараах нөлөөлөл, үр дагавар учрах магадлалтай. Үүнд:

- Овоо суврага зэрэг нутгийн ариун дагшин газар үйлддэг түүхэн уламжлалт зан үйл, цаашилбал эдгээр зан үйлийн ёслолыг гүйцэтгэхэд мөрддөг дэг жаяг, хорио цээрийн уламжлалыг устгах,
- Төслийн газар нутаг дах шашин шүтлэг, холбогдох дэг ёсыг нь өөрчлөх,
- Малчин ардын олон зууны туршид хадгалан тээж ирсэн нутгийн соёл, ёс заншилд харш, гадны шинэ соёлыг дэлгэрүүлэх зэргээр соёлын ялгаа гарах,
- Уламжлалт гар урлал, ёс заншил, аман зохиол, дуу хуур зэрэг мартагдах
- Монгол хэлэнд харь хэлний үгийг ихээр хэрэглэх зэргээс үүдэн төрөлх монгол хэлний цэвэр ариун байдлыг алдагдуулах
- Нутгийн ард иргэдийн үнэ цэнийн хэмжүүр, төлөв байдал аажмаар доройтож байгаагийн улмаас онцлог шинж чанар нь алдагдах,
- Цалинтай ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотойгоор уламжлалт амьдралын хэв маягаасаа хөндийрөх.

Соёлын өвд хандах хандлагыг Оюу Толгойгоос явуулсан Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны нэгэн хэсэг болгон тодруулан гаргасан.¹⁰ Биет бус өвтэй холбоотой ард иргэдийн санаа зовоосон асуудлуудыг 2009 оны Нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тайлан болон 2009 оны Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ (ННБҮ)-нд оруулсан¹¹. ННБҮ-гээр соёлын өв, ялангуяа уламжлалт соёлд учрах гарз хохирол, аюул заналын талаарх олон нийтийн үзэл хандлагыг тоймлон танилцуулсан.

Судалгааны дүгнэлтээс үзэхэд ихэнх ахмад хүмүүс өргөнөөр хэрэглэгдэхээ больсон уламжлалт мэдлэг арга ухаанаа (үлгэр домог ярих, дуу хуур заах) хойч үеийнхэндээ өвлүүлж чадахгүй байна. Ийнхүү зан төлөвт гарсан өөрчлөлтөөс үүдэн залуучууд нь ахмадуудаасаа монгол үндэстнийхээ уламжлалт соёлоо суралцахгүй байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 27 хувь нь уламжлалт гэр бүлийн бүтцэд бодит өөрчлөлт гарсан учраас гэр бүлийн доторх ахмад настан, залуучуудын хоорондын харилцаа алдагдсан гэж үзжээ. Уламжлалт мэдлэг, арга ухаан алдагдахад нөлөөлж буй өөрчлөлтүүд гэвэл уламжлалт амьдралын хэв маяг, зан үйлээр амьдарч буй хүүхдүүдийн тоо улам цөөрч, хотжилт хүрээгээ тэлж, мал маллахын оронд ажил эрхлэх болсон зэрэг юм.

ННБҮ-ний сэдэвчилсэн хэлэлцүүлгийн үеэр уламжлалт соёлоо алдахтай холбоотой дараах асуудлуудыг дэвшүүлэн тавьсан:

- Уламжлалт мэндлэх ёс болон настай хүмүүст хүндэтгэл үзүүлэх зан үйл алдагдсан буюу ялангуяа хүүхэд, залуучууд буруу хийдэг;
- Өнөө үед нүүдлийн амьдралын хэв маяга хадгалан амьдарч буй гэр бүлийн тоо цөөрч байгаагаас шалтгаалан нүүдлийн соёл, уламжлал түлхэгдэн гадуурхагдаж байна. Амьдралын хэв маяг гарсан энэхүү өөрчлөлтөөс үүдэн тэмээ унахдаа тусгай хазаар хэрэглэх, нүүдэлчин бусад айл өрхүүдтэй харилцан бие биенээсээ суралцах зэрэг нүүдэлчний соёлын түүхэн хандлагыг залуучууд улам бүр хэрэглэхээ больж байна;

¹⁰ Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны үнэлгээ, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв, 2009.

¹¹ Оюу Толгой төслийн Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв, 2009 оны 9 сар.

- Яриандаа олон гадаад үг, нэр томъёо ашиглах болсон нь монгол хэлэнд муу нөлөөлөл үзүүлж байна,
- Олон хүн тахилгатай уул ус, газар нутгийнхаа нэрийг мэдэхээ болилоо,
- Ургийн бичиг хөтлөхөө бараг больсон учраас ураг төрлийн холбоо, өвөг дээдсээ мэддэггүй боллоо,
- Уламжлалт эсгий урлал үгүй боллоо, залуучууд эмээлийн бүүрэг, эсгий гутал зэрэг эсгий эдлэл хийхээ больсон,
- Залуучууд үндэсний дээл, хувцсаа төдийлөн өмсөхөө больж, монгол дээлний хэв маяг, загвар, зохиомж нь өөрчлөгдсөөр байна¹²;
- Малчид аймаг, сумын төв, нийслэл хот руу шилжин суурьшиж, цалинтай ажил эрхлэх болсон ба малаа өөр айлаар эсвэл гуравдагч этгээдээр харуулдаг боллоо.

2007 онд явуулсан Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засгийн суурь судалгаанаас үзэхэд Өмнөговь аймгийн судалгаанд хамрагдсан нийт айл өрхийн 46 орчим хувь нь уламжлалт соёл устаж үгүй боллоо гэдгийг хүлээн зөвшөөрсөн¹³.

Бүс нутгийн томоохон ажил олгогчийн хувьд Оюу Толгой нь ажиллах хүчний балансыг урьд нь голлож байсан хөдөө аж ахуйгаас уул уурхай болон бусад туслах салбарууд руу шилжүүлэх нөөц бололцоотой юм.

Нэгэнт тогтсон амьдралын хэв маяг (тухайлбал, хөдөөгийн нүүдэлчин малчдын амьдрал) нь Монголын биет бус соёлын өвийн нэг тулгуур үндэс нь мөн.

Нутгийн болон гадны оршин суугчид холилдож, хөдөөнөөс хот, суурин газар руу шилжин суурьшиж байгаа нь орчин үеийн амьдралын хэв маягийг илүү дэвшилттэй, загварлаг хэмээн шохоорхоход хүргэж, шашны уламжлал, баяр ёслол, шүтлэгт газруудын зан үйл, хамт олон бүлгээрээ хэвшиж мөрдөж ирсэн зан үйл, дэг жаяг, ёсзүй, хорио цээрүүдийг үл ойшоон мартаход хүргэж байна.

Эдгээр нөлөөлөл нь төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэр дээр ажиллах хүний тоо 14,800-д хүрнэ гэж тооцоолж байгаа бүтээн байгуулалтын оргил үед илүү хүчтэй мэдрэгдэх болно. Гэхдээ гадаадын иргэдийн тоог шаардлагатай хэмжээнд цөөлөх замаар ажиллах хүчний тооны харьцааг үйл ажиллагааны явцад багасгаж тогтвортой байлгахгаар тооцоолж байна.

Хэдий тийм ч гэлээ ажил хайж, мөн эдийн засгийн шалтгаанаар ирэх бусад шилжин ирэгсдийн бүс хооронд болон бүс доторх шилжилт, хөдөлгөөн үргэлжилсээр байх бөгөөд Ханбогд суманд урт хугацаагаар эсвэл түр зуур суурьших хүмүүсийн хувь хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

Төслийн ажилчдыг тараах болон ажиллах хүчнийг өөрийн үндсэн харьяалал бүхий нутаг руу нь буцааснаар уламжлалт амьдралын хэв маягт үзүүлэх дарамт шахалт багасна. Уурхайг хаасны дараа Оюу Толгой төсөлд ажиллаж байсан нутгийн уугуул биш оршин суугчид нь энэ бүс нутаг хэрэгжих өөр төсөл дээр ажиллах болсноор эсвэл энэхүү газар нэгэнт суурьшсан зэрэг шалтгаануудаар төслийн бүс нутагт үлдэн амьдрах магадлалтай. Хэдий тийм ч, тэдгээр иргэд нь нутгийн ард иргэдтэй нэгдэн ялгаагүй нэг нутгийн оршин суугчид болох учраас биет бус өвийн уламжлалд гадны хүчний нөлөөлөл тийм ч хүнд, ноцтой нөлөөлөхгүй гэж үзэх боломжтой.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Соёлын өвийн хөтөлбөр (СӨХ) 1 дүгээр шат

Оюу Толгой нь биет бус соёлын өвийн орлуулашгүй үнэ цэнэ болон тэдгээртэй холбоотой өөрийн нөлөөллийн бүс нутаг дах баялаг зан үйлийг бүрэн хэмжээгээр нь ойлгон хүлээн зөвшөөрч байна. Оюу Толгой нь нутаг орны эдгээр баялаг биет бус өв соёлын нөөц нь мартагдахгүй байх болон

¹²Дээл гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд өмсгөл ижил, нүүдэлчин амьдралд зохицсон Монгол үндэсний хувцас. Дээлийг янз бүрийн өнгөтэй, 6-7 м хүртэлх хэмжээтэй давуугаар хийдэг.

¹³Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, Судалгааны төв, 2009.

олон нийтэд таниулах явдлыг хангах үүднээс Оюу Толгойн СӨХ болон холбогдох судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн юм. СӨХ-ийн танилцуулгыг соёлын өвийн ач холбогдол болон энэхүү чиглэлээр Монголын Олон Улсын Өвийн Багийн хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаануудыг тайлбарлан таниулах үүднээс олон нийтэд зориулан бэлтгэн гаргасан юм. (Хавсралт А-г харна уу).

Өмнөговь аймагт орших уламжлалт тахилгат газруудын бүртгэлийг СӨХ-ийн 1 дүгээр шатанд хийсэн бөгөөд ялангуяа төслийн бүс нутагт орших уламжлалт соёлын газруудын нарийвчилсан жагсаалтыг Түүхийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн угсаатны зүйн судалгааны нэг хэсэг болгон нэгтгэн гаргасан. Энэхүү жагсаалтад нутгийн иргэдийн хувьд сүсэг бишрэл, шашны үнэ цэнэ бүхий, уул толгод, рашаан ус гэх мэт байгалийн тогтоц, мөн оршуулгын газар, овоо, булш зэргийн бүртгэлийг багтаасан. Тэдгээр ариун дагшин газруудтай холбоотой үлгэр домог, хорио цээр болон зан үйлүүдийн талаарх мэдээ баримтууд ч мөн энд орно. Тухайн газруудын байршил болон холбогдох зан үйлийг мэдэх нь тэдгээр газруудын талаар мэдлэгтэй болж, зүй зохисгүй үйлдэл гаргахаас болгоомжлох замаар үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ оруулна. Шүтлэгтэй газруудын жагсаалтыг нэгтгэн гаргаж, шинэчлэх арга хэмжээ нь уурхайн хөгжлийн бүхий л үе шатуудад үргэлжлэн хийгдсээр байх болно.

Төслийн хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн арга хэмжээний талаар ард иргэдэд мэдээлэл өгөх болон соёлын өвийн ач холбогдол, гарах нөлөөлөл болон орон нутгийн (жишээ нь, төслийн нөлөөллийн бүст) төдийгүй бүсийн түвшинд (жишээ нь, Өмнөговь аймгийн түвшинд) соёлын өвийг хамгаалах оновчтой арга туршлагауудын талаар орон нутгийн иргэд болон оролцогч талуудтай зөвлөлдөх замаар соёлын өвтэй холбоотой болон ард иргэдийн таатай байдлыг алдагдуулахад нөлөөлсөн нөлөөллийг багасгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

Соёлын өвийн зөвлөлдөх хороо

СӨХ-ийн салшгүй нэг хэсэг бол зөвлөлдөх болон оролцогч талуудын уулзалт юм. 2010 онд оролцогч талуудын хэд хэдэн уулзалтуудыг зохион байгуулснаар Өмнөговь аймаг дахь СӨХ-ийг дэмжих зорилгоор Зөвлөлдөх хороог байгуулсан. Зөвлөл орон нутгийн иргэд, сонирхогч талууд, археологийн байгууллага болон Оюу Толгойн төлөөлөл бүхий 15 гишүүнээс бүрдэнэ.

Дэмчигийн хийдийн суврагыг барьж байгуулсан нь

СӨХ-өөр дамжуулан Дэмчигийн хийдийн суврагыг (Тэнгэрийн Авид Реалм) барих ажлыг Оюу Толгой ивээн тэтгэсэн ба түүнчлэн Дэмчигийн хийдийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлсэн нь гаднаас ирэх төдийгүй нутгийн иргэдийн анхаарлыг татах болсон.

Уламжлалт урлал, музей болон соёлын их наадамд дэмжлэг үзүүлсэн нь

СӨХ-ийн 1 дүгээр шатанд мөнгөний дархан, төмрийн дархан, эсгий хивс урлал¹⁴, малчдын хэрэглээ болох эмээлийн бүүрэг, татлага зэрэг эдлэлийн урлал, мал маллах арга техник¹⁵, Монголын үндэсний сууц болох гэр барих, гэрт амьдрах зэрэг уламжлал, зан үйл, арга ухааныг судалсан. Буддын шашин, бөө мөргөл зэрэг шашны зан үйлүүд болон бурхан, шүтээн тахих зэрэг уламжлал, зан үйлүүдийг тодорхойлон тайлбарласан. Түүнчлэн сүүлийн жилүүдэд сэргээд байгаа ургийн овог хэрэглэх уламжлал, улмаар төрөл садангуудаа танин мэдэх, мөн уртын дуу, жүжиг,

¹⁴ Монголын уламжлалт эсгий дэвсгэрийг дуглууур, тойрог гэж нэрлэх ба зарж борлуулахаас илүүгээр цөөн тоогоор өөрийн хэрэгцээнд зориулан гараар оёж урладаг.

¹⁵ Малчин ардын мал маллах арга ухаан үеэс үед дамжин өвлөгдөж байдаг.

уламжлалт тоглоом зэргийг судлаад байна.¹⁶ ОТ нь Ханбогд сумын наадмыг цаашид санхүүжүүлсээр байх болно.¹⁷

Оролцогч талуудын өмнөх хэлэлцүүлгээр Ханбогд сумын музейг оруулаад орон нутгийн музейнүүдийг засаж, шинэчлэхэд хувь нэмэр оруулах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг олон нийтийн зүгээс гаргасан¹⁸. Эдгээр үйл ажиллагаануудыг СӨХ-ийн хүрээнд хэлэлцэх шатанд байгаа бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх хуваарийг мөн боловсруулна.

Оюу Толгой дахь хөдөлмөр эрхлэлт

Нүүдлийн МАА-гаас цалинтай ажил руу шилжих шилжилт нь Өмнийн Говийн уул уурхайн томоохон төслүүд хэрэгжих болсноор ихсэх болно. Олон тооны малчид эдгээр компанид ажиллаж эхлэх нь зайлшгүй юм. Уламжлалт амьдрал ахуйгаа алдаж байгаа нь биет бус соёлын өвд ихээхэн сөрөг үр дагавартай байх нь тодорхой. Энэхүү сөрөг нөлөөллийн нэг хэсгийг адил тэгш хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх болон ажил дээрээ соёлын уламжлалаа хадгалах замаар төслийн хүрээнд багасгаж болох юм.

Уламжлалт өвийг олж илрүүлэх болон хадгалж хамгаалах асуудалд үзүүлэх дэмжлэг- СӨХ – р үе шат

Уламжлалт өвийг олж илрүүлэх, хадгалж хамгаалах арга замаа тодорхойлох, мөн үүний зэрэгцээ түргэн хурдацтай хөгжиж буй өөрчлөлт, шинэчлэлийн энэ цаг үед Монголын уламжлалт соёлыг хадгалж, хамгаалах боломж нөхцлийг бүрдүүлэх нь Оюу Толгой төслийн Соёлын өвийн хөтөлбөрийн эн тэргүүний зорилтуудын нэг юм. Энэхүү зорилтыг үйл ажиллагааны цэгцтэй төлөвлөгөө, ялангуяа орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээний ач холбогдолтой газар нутаг, үнэт зүйлсийг үр дүнтэй хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд чиглэсэн соёлын өвийн төлөвлөгөөний дагуу төслийн хүрээнд шийдвэрлэх боломжтой. Энэхүү ажлыг Төслийн зүгээс санаачлан боловсруулж үйл ажиллаганы нарийвчилсан төлөвлөгөө, ялангуяа Соёлын Өвийн Төлөвлөгөө нь дархан цаазат болон үндэсний, бүс нутгийн, орон нутгийн чухал ач холбогдолтой газруудыг хамгаалах үр дүнтэй арга хэмжээг авах талаар анхаарлаа хандуулна. Уг төлөвлөгөөг боловсруулах нь Оюу Толгойн санал болгосон Монголын Олон улсын Өвийн Багийн үндсэн зорилтуудын нэг бөгөөд тус баг Оюу Толгой төслийн хүрээнд СӨХ-ийг хэрэгжүүлэхэд оролцон ажиллах юм. Ингэхдээ олон улсын мэргэжилтний өвийн менежментийн талаарх мэдлэг, туршлага болон Монголын соёлын өвийн тухай асуудлуудыг нэгтгэн судалж ажиллах юм. СӨХ нь 2-р шатны тайланд орно. Соёлын өвийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах үйл явц нь 3 хэсгийг хянан магадалсан .Үүнд: биет соёлын өвийн эд зүйлс, биет бус нөөц, дагалдах олон нийтийн хөтөлбөр. Эхний 2 ангилал нь өвийн бүрдүүлэгч хэсгүүдэд хамаарагдана: тодорхой газар нутгууд болон эд өлгийн зүйлс, цаашилбал, ёс заншил, зан үйлүүд. 3 дах ангилалд өвийн талаарх мэдлэг, ойлголтыг сургууль, музейгээр дамжуулан түгээн дэлгэрүүлэх, цаашилбал өвийг аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийн ашиг орлого олох хэрэгсэл болгон ашиглах боломжууд орно.

Нөлөөллийн зэрэглэл

Бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө нэгэнт бий болоод байгаа нутгийн ард иргэдэд таагүй сэтгэгдэл төрүүлэх, хэн нь мэдэгдэхгүй хүмүүс шүтлэгтэй газар нутгийг хөндөн сэвтээх зэрэг биет бус соёлын өвд нөлөөлөх төслийн зарим нөлөөлөл нь **урт хугацаагаар** үргэлжилж магадгүй байна. Цаашилбал бүтээн байгуулалтын ажлын дараа болон үйлдвэрлэлийн үе шатанд төслийн газар нутаг дээр гаднаас ирж ажилласан хүмүүс үлдэн, суурьшиж болох талтайг харгалзан үзэхгүй байж

¹⁶ Өмнөговь аймаг, Оюу Толгой төслийн нөлөөллийн газар нутаг дахь Биет бус өв судлалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Оюу Толгой төслийн Өмнөговь аймаг дахь Соёлын өвийн хөтөлбөрийн 1 дүгээр шатны үйл ажиллагааны тайлан “Өнгөрснийг хадгалж, Одоо үеийг хамгаалъя”. Састэйнабилити Ийст Эйжиа ХХК болон Монголын Шинжлэх ухааны академийн, Археологийн хүрээлэн бэлтгэн гаргасан. (2011 оны 2 сар).

¹⁷ Наадам гэдэг нь орон даяар 7 дугаар сарын 11-ээс 13-ны хооронд тэмдэглэн өнгөрүүлдэг үндэсний баяр бөгөөд морины уралдаан, бөх, сур хараа гэсэн гурван төрлийн уралдаан тэмцээнээс бүрддэг.

¹⁸ Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ (НЭЗНУ). Эцсийн тайлан. Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв хамтран бэлтгэн гаргасан, Улаанбаатар, 2009 оны 9-р сар.

болохгүй. Ингэснээр соёлын болон оюун санааны уламжлалд нөлөөлөх нөлөөлөл нь цаашид ч бас байна гэсэн үг. Дунд шатны нөлөөлөл нь аль хэдийнээ илрээд байгаа учраас цаашид ийм нөлөөлөл байх нь **гарцаагүй** юм.

Оюу Толгой төслийн үйл ажиллагааны улмаас биет бус соёлын өвд нөлөөлөх нөлөөллийн хэмжээ нь Монгол орны бусад бүс нутагт бий болоод байгаа төлөв, хандлагуудыг давтсан, тэдэнтэй ижил шинжтэй байгаа учраас нөлөөллүүд улам бүр **өргөн хүрээг** хамрах төлөвтэй байна. Оюу Толгойн хэрэгжүүлсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд нь нийт нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ өгч байгаа хэдий ч цэвэр нөлөөлөл нь (уламжлал, соёл уусах, алга болох) **дунд сөрөг нөлөөлөл** нилээн байсаар байна. Энэхүү хор хохиролын хэмжээ нь Монгол улсад болон гадаадад (3 дахь ашиг сонирхлын бүлэг) болно. Хэдийгээр уламжлалт ахуйгаас хөндийрэх нь лунл сөрөг нөлөөллийн үр дагавар болох хэдий ч цалин хөлстэй ажилд орсноор эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээ авах, орлого, санхүүгээ нэмэгдүүлэх болон хоол хүнс болон халаалт зэрэг үйлчилгээнд хүрэх боломжийг бүрдүүлэх тул мал аж ахуй эрхлэхээс давуутай байж болох юм. СӨХ-ийн хүрээнд хийгдэж байгаа сэргээн засах болон судалгааны ажлууд нь биет бус соёлын өвийн нөөцийг хадгалж хамгаалахад илүү нөхцөл боломжийг бүрдүүлж, төсөл хэрэгжиж буй газар болон Өмнөговь аймагт нутгийн иргэдийн аливаа зан заншил, гар урлалыг илүү ойлгож таниулахад чиглэгдэж байна. Энэ нь бүс нутгийн хэмжээнд ашиг тусаа өгөх **зэрэг** нөлөөлөл юм. Оюу Толгой нь СӨХ-ийг холбогдох мэргэжлийн байгууллага болон оролцогч талуудтай цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд энэхүү хөтөлбөрөөрөө дамжуулан төслийн нөлөөллийн бүс нутагт хариуцлагатай уул уурхайг эрхлэн явуулах, соёлын өвийг хамгаалах талаарх хүлээсэн амлалт, үүргээ хэрэгжүүлэх юм.

СӨХ-ийн 1 ба 2 дугаар шатны үр дүнтэй Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээр байгалийн нөөц баялгийг олдворлож байгаа бусад компаниуд ч танилцан үзэх боломжтой.

11.4 ҮЛДЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ

Оюу Толгой төслийн хүрээнд хийгдсэн Соёлын өвд нөлөөлөх байдлын үнэлгээнээс дараах дүгнэлтүүд гарч байна. Үүнд:

Оюу Толгой төслийн Уурхайн Лицензит Талбай дах археологийн зарим дурсгалууд сүйтгэгдсэн байна. Тухайлбал, зэсийн эртний орд, чулуун бүтцүүд гэх мэт; Эдгээр дурсгалуудын хувьд бүрэн судалгаа хийгдсэн ба цаашид нэмэлт ажил шаардлагагүй гэсэн ШУА-ын Археологийн Хүрээлэнгийн зөвшөөрлийн бичгийг Оюу Толгойд өгсөн;

Оюу Толгой төсөл нь ус дамжуулах хоолой тавих шугамын дагуу палентологийн зарим нөөц алдагдахад нөлөөлсөн . Эдгээр нөөцийг олдворуудыг шилжүүлэх ажлын ажил хэрхэн явагдсан талаар бүрэн хэмжээний шалгалтыг Палентологийн төв явуулж 2012 оны 6-р сарын 1 гэхэд дуусгасан;

- Ус дамжуулах хоолой тавих шугамын дагуу ямар нэг археологийн дурсгалууд олдоогүй тул нөлөөлөл үүсэхгүй байх боломжтой хэдий ч бүтээн байгуулалтын явцад ажиглаж байх шаардлагатай. Хэд хэдэн өрөмдлөгийн цооногууд оршуулгын газруудтай ойрхон байгаа учраас тэдний хувьд хамгаалалтын хил зааг тогтоох зэргээр нэмэлт хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай болно;
- Хил рүү явах замтай холбоотой гарсан гол нөлөөллүүд нь замын чиглэлд хийсэн өөрчлөлтийн үр дүнд буурсан;
- Хөрс хуулалт, газар шорооны ажил, үйлдвэр барих, туслах зам тавих зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас болж цаашид дурсгалууд гэмтэх, тэднийг шилжүүлэх шаардлага гарч болох юм;
- Хэдийг нарийвчилсан судалгаа шинжилгээний ажлууд хийгдсээр байгаа боловч биет соёлын дурсгалууд шинээр гарч ирж болзошгүй юм.

- Төслийн талбай доторх дурсгалуудын хувьд “Тохиолдолын олдворын журам”-ыг дагаж мөрдөнө;
- *Оюу Толгойн Соёлын өвийн менежментийн төлөвлөгөөг* хэрэгжүүлэх нь Оюу Толгойд соёлын өвийг бүртгэх, хамгаалах ажлаа цаашид ч үргэлжлүүлэн хийх баталгааг олгох ба нутгийн иргэд ч энэ үйл ажиллагаанд оролцсон хэвээр байх юм.

Жавхланта уул зэрэг төслийн бүсээс гадуурх соёлын дурсгалууд болон биет бус соёлын өвүүдийг уламжлалт ёс заншил гэдэг утгаар нь хамгаалах нь чухал болохыг Оюу Толгой төсөл хүлээн зөвшөөрч байгаа юм. Эдгээр зүйлсэд урт хугацааны СӨХ-ийг хэрэгжүүлэх, соёлын тухай мэдлэг олгох сургалтууд, замын хөдөлгөөнийг хянах, сонор сэрэмжийг дээшлүүлэх зэрэг арга замуудыг хэрэглэх байдлаар хяналт тавьж, удирдан зохицуулж ажиллах болно.

Хүснэгт 11.1-д Соёлын өвд учирч болзошгүй нөлөөллүүдийг хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 11.1: Соёлын өвийн нөлөөллийн хураангуй

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөллийн ангилал	(4) Нөлөөллийн зэрэглэл	Боловсруулах, Сайжруулах, эсвэл бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого, журам	Үлдэх нөлөөллийн зэрэглэл
Биет соёлын өвийн нөөц алдагдах: : Уурхайн Лицензит Талбай	ОУ-ын болон үндэсний орон нутгийн хүн ам, Өмнөговь аймаг, сумын оршин суугчид	Барилга	Үргэлжлэх хугацаа: Урт хугацааны Хамрах хүрээ: Өргөн хүрээний Магадлал: Гарцаагүй	Их сөрөг	<ul style="list-style-type: none"> ■ Биет соёлын өвийн судалгаа хийгдсэн ■ Зэсийн ордны малтлага- Түрэг толгойн эртний зэсийн уурхай (дууссан) ■ Амьтны тахил өргөлийн газрын малтлага (дууссан) ■ Динозаврын өндгүүдийг малтаж гаргах, УБ-т шилжүүлэх (дууссан) ■ СӨХ-ийн 2 –р шатанд хадны сүг зургийг хадгалах ■ Зэсийн ордны малтлага, угсаатны зүйн үнэлгээ болон аман түүхийг баримтжуулах ажил (дууссан) ■ Ханбогд дахь зэсийн ордны малтлагын эд зүйлсийг ЗД –ээр үзүүлэх боломж (МШУА-ийн Археологийн Хүрээлэн судлан үзэж байна) ■ Бор Овоо бүлгийг шилжүүлэх 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Тохиолдолын олдворын журам	Бага зэргийн сөрөг
Биет соёлын өвийн нөөц алдагдах: : Гүний Хоолойн цооног, усны хоолой	Сумын оршин суугчид ба малчид	Барилга	Хугацаа: Дунд хугацааны Хамрах хүрээ: Орон нутгийн түвшин Магадлал: Магадлалтай	Бага зэргийн сөрөг	<ul style="list-style-type: none"> ■ Биет соёлын өвийн судалгаа хийгдсэн ■ Нөлөөлөл үүсэхээс зайлсхийхийн тулд ус дамжуулах хоолойн маршрутыг зөв сонгох ■ Ус дамжуулах хоолой барихдаа 3 булшны газрыг зааглах, хашаа барих ■ Барилгын ажлын үед палентологийн хяналт шинжилгээ хийх ■ Үлэг гүрвэлийн бүрэн бус чулуужсан үлдэгдлийн палентологийн малталт болон Улаанбаатар луу шилжүүлэх 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Тохиолдолын олдворын журам	Бага зэргийн сөрөг
Биет соёлын өвийн нөөц алдагдах: : Түр нисэх буудал	Сумын оршин суугчид ба малчид	Барилга	Хугацаа: Богино хугацааны Хамрах хүрээ: Хязгаарлагдмал Магадлал:	Нөлөөгүй	<ul style="list-style-type: none"> ■ Биет соёлын өвийн үнэлгээ хийгдсэн ■ Судалгаагаар ач холбогдолтой дурсгал олоогүй 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Тохиолдолын олдворын журам	Нөлөөгүй

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөллийн ангилал	(4) Нөлөөллийн зэрэглэл	Боловсруулах, Сайжруулах, эсвэл бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого, журам	Үлдэх нөлөөллийн зэрэглэл
			Магадлал багатай				
Биет соёлын өвийн нөөц алдагдах: Байнгын нисэх буудал	Сумын оршин суугчид	Барилгын ажлын	Хугацаа: Богино хугацааны Хамрах хүрээ: Хязгаарлагдсан Магадлал: Өндөр магадлалтай	Нөлөөгүй	<ul style="list-style-type: none"> Биет соёлын өвийн судалгаа хийгдсэн Түүхийн судалгаагаар ач холбогдолтой дурсгал олдоогүй Шав тавих ёслол хийх (олон нийтийг оролцуулаад) 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Тохиолдолын олдворын журам	Нөлөөгүй
Биет соёлын өвийн нөөц алдагдах: : Цахилгаан дамжуулах шугам	Бүс нутгийн (аймаг) болон сумын оршин суугчид	Барилгын ажлын	Хугацаа: Урт хугацааны Хамрах хүрээ: Хязгаарлагдмал Магадлал: Гарцаагүй	Дунд зэрэг сөрөг	<ul style="list-style-type: none"> Биет соёлын өвийн судалгаа хийгдсэн 2011 онд авран хамгаалах малтлага хийсэн ба булшнаас гарсан хүний хэсгүүдийг УБ хот руу судлахаар авч явсан. Нийтлэг үнэ цэнэ бүхий цөөн үлдэгдэл олдсон 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Тохиолдолын олдворын журам	Бага зэргийн сөрөг
Биет соёлын өвийн нөөц алдагдах: : Оюу Толгой – Гашуун Сухайтын зам, болон карьер	Бүс нутгийн (аймаг) болон сумын оршин суугчид	Барилгын ажлын	Хугацаа: Урт хугацаа Хамрах хүрээ: Хязгарлагдмал Магадлал: Гарцаагүй	Дунд зэрэг сөрөг	<ul style="list-style-type: none"> Биет соёлын өвийн судалгаа хийгдсэн 2011 онд авран хамгаалах малтлага хийсэн ба булшнаас гарсан хүний араг ясыг УБ хотруу палеонтологийн судалгаа хийхээр авч явсан. Үнэ цэнэ бүхий зүйлс олдоогүй Бүтээн байгуулалтын үед дурсгалт газрууд өртөхгүй 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Тохиолдолын олдворын журам	Бага зэргийн сөрөг
Төслийн үйл ажиллагаанаас биет соёлын өвийн нөөцөд шууд бус нөлөөлөл	Өмнөговь болон сумын оршин суугчид	Барилга, Үйл ажиллагаа болон уурхайг татан буулгах	Хугацаа: Урт хугацааны Хамрах хүрээ: Хязгаарлагдмал Магадлал: Гарцаагүй	Дунд зэрэг сөрөг	<ul style="list-style-type: none"> Соёлын өвийн тогтоосон газруудын хамгаалалт (хил зааг тавих, хашаа барих, тэмдэгжүүлэх). Оюу Толгой төслийн СӨХ-ийн нэг хэсэг болгон археологийн газруудыг оруулах Газар зүйн мэдээллийн санг бий болгох Соёлын болон түүхийн өвийн талаар хүмүүст мэдлэг олгох материалуудыг бэлтгэж, тарааж түгээх 	D13: Соёлын Өвийн Менежментийн төлөвлөгөө Оюу Толгой төслийн СӨХ Оюу Толгойн Кэмп дээр биеэ зөв авч явах, харилцааны соёл Оюу Толгой замын хөдөлгөөний менежментийн	Бага зэргийн сөрөг

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөллийн ангилал	(4) Нөлөөлийн зэрэглэл	Боловсруулах, Сайжруулах, эсвэл бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого, журам	Үлдэх нөлөөллийн зэрэглэл
					<ul style="list-style-type: none"> Тоос шороо менежментийн арга техникүүдийг хэрэглэх Тодорхой чиглэлүүдээр зорчихийг хориглох ШУА-ын Археологийн Хүрээлэн эсвэл Палентологийн төвөөс тодорхойлсон тохиодолд малтлагын ажлыг хийх Биет соёлын өвийн дурсгалт газруудад хяналт шинжилгээг тогтмол хийх 	төлөвлөгөө	
Соёлын өвийн газруудад үүсэх тооцоологдсон нөлөөлөл/дурсгалыг санаатай хөндөх, эвдэж сүйтгэх	Монгол улсын Засгийн Газар ба сонирхлын бүлгүүд, бус нутгийн ба сумын иргэд	Барилгын ажлын ба үйлдвэрлэлийн үе шат болон уурхайг татан буулгах	Хугацаа: Урт хугацааны Хамрах хүрээ: Өргөн Магадлал: магадлалтай	Их сөрөг	<ul style="list-style-type: none"> Оюу Толгой төслийн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд соёлын өвийн талаарх ойлголт, мэдлэг олгох сургалт хийх Оюу Толгойн СӨХ-ийн хүрээнд шүтлэгтэй газруудыг тогтоох, хадгалж хамгаалах Нутгийн иргэд, оролцогч талуудтай үргэлжлүүлэн хэлэлцүүлэг хийх. 	Оюу Толгой кэмп дээр биеэ зөв авч явах, харилцааны соёл	Бага зэргийн сөрөг
Биет бус соёлын өвд нөлөөлөх нөлөөлөл (уламжлал, уламжлалт ахуй амьдрал, ардын дуу хуур, баяр наадам, уламжлалт спорт, болон бусад биет бус соёлын өв)	Монгол улсын Засгийн Газар ба сонирхлын бүлгүүд, бүсийн ба сумын иргэд	Барила, үйл ажиллагаа, уурхайн хаалтын үе	Хугацаа: Урт хугацааны Хамрах хүрээ: Өргөн хүрээний Магадлал: Магадлалтай	Их сөрөг	<ul style="list-style-type: none"> СӨХ-ийн 1 дүгээр шатанд Жавхланта уулыг судлах Сүмийг засварлах болон жил бүрийн наадамд зориулан Тэнгэрийн орон суварга босгох ажлуудад шууд санхүүжилт үзүүлэх Наадмын үйл ажиллагааг дэмжих (жил бүр) Төслийн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд соёлын чиглэлээр сургалт явуулах Орон нутгийн иргэдтэй хэлэлцүүлэг үргэлжлүүлэн хийх ШУА-ийн Археологийн Хүрээлэн, Түүхийн хүрээлэнгүүдийг түүх, угсаатны зүйн судалгаанд татан оролцуулах Өмнөговь аймагт, төдийгүй ялангуяа Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд байрлах шүтлэгтэй газруудын байршлын жагсаалтыг гаргаж, 	Оюу Толгой, Кэмп дээр биеэ зөв авч явах, харилцааны соёл Оюу Толгойн СӨХ бө Түүхийн хүрээлэнгийн хийх угсаатны зүйн судалгаа D16: Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө	Дунд зэргийн сөрөг

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөллийн ангилал	(4) Нөлөөллийн зэрэглэл	Боловсруулах, Сайжруулах, эсвэл бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого, журам	Үлдэх нөлөөллийн зэрэглэл
					<p>жагсаалтад байгалийн үзэсгэлэнт газар, уул толгод, рашаан зэрэг байгалийн тогтоц бүхий газар, нутгийн иргэдийн сүсэглэж биширдэг газрууд, булш, овоо гэх мэт газруудыг багтаана. Тэдгээр шүтлэгтэй газруудтай холбоотой үлгэр дотог, хорио цээр, зан үйлийг түүнчлэн тэмдэглэсэн.</p> <ul style="list-style-type: none"> ■ СӨХ-ийн 2 дугаар шатыг төлөвлөж хэрэгжүүлж эхэлсэн. Соёлын өвийн талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа (орон нутгийн уламжлал, зан үйлийг) болон сумын соёлын байгууллагуудыг чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх нь энэ үе шатанд хийгдэх ажлын хэсэг байх болно. ■ Ханбогд сумын музейг өргөтгөх ажлыг санхүүжүүлэх буюу уг ажлыг нь хийж гүйцэтгэж өгөх ■ Бор Овоо булгийг өөрчлөх 		

Тайлбар:

(1) Нөлөөлөлд өртөгч: нөлөөлөлд өртсөн эсвэл бусад сонирхогч талуудыг тодорхойлдог

(2) Төслийн үе шат: Барилга, Үйл ажиллагаа, Уурхайг татан буулгалт болон уурхайн хаалт

(3) Нөлөөллийн ангилал:

Үргэлжлэх хугацаа: Богино хугацааны, Дунд хугацааны, Урт хугацааны

Хамрах хүрээ: зөвхөн орон нутгийн шинжтэй; орон нутгийн шинжтэй; хязгаарлагдмал; өргөн хүрээний

Магадлал: магадлал маш бага; магадлал муутай; магадлалтай; гарцаагүй

(4) Нөлөөллийн зэрэг: Их хэмжээний сөрөг; дунд зэргийн сөрөг; бага хэмжээний сөрөг; нөлөөгүй; Эерэг

ХАВСРАЛТ А: СОЁЛЫН ӨВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН СОЁЛЫН ӨВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Өмнөговь аймгийн ирээдүйн хөгжилд соёлын өвийн дурсгалыг хамгаалахын ач холбогдол

Говь нутагт олон сая жилийн туршид амьдрал үргэлжилсээр ирсэн бөгөөд энэхүү газар нь эргэн тойрон намгаар хүрээлэгдсэн асар том далай тэнгис байсан хэмээхэд өнөөдөр итгэхэд хэцүү ч энэ газар шороо 200-60 сая жилийн тэртээ аврага том үлэг гүрвэлүүдийн эзэмшилд байсныг гэрчлэх тэдгээрийн өндөг, яс зэрэг олдворууд илрэн олддоогоороо дэлхийд алдаршсан.

Хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад зэрлэг амьтдыг гаршуулсан нь тэдний амьдралд томоохон өөрчлөлтийг бий болгон амьдралын нүүдэлчин хэлбэрийг хөгжүүлсэн. Энэхүү нүүдэлчин овог аймгуудын эзэнгүй зэлүүд газрыг хоромхон хугацаанд өөрийн болгон эзэмшиж чадах уян хатан нийгмийн бүтэц нь хожмын Монголын Эзэнт гүрнийг байгуулахад хамгийн чухлаар нөлөөлсөн зүйлүүдийн нэг болсонтой маргах аргагүй юм.

Сүүлийн жилүүдэд тулгарч буй асуудлуудын нэг бол малчдын нүүдлэхүй хэв маяг нь орчин үеийн амьдралын хэв маягаас шалтгаалан өөрчлөгдөж байгаа явдал юм. Монголчууд ХХ зууны ихэнх хугацаанд өөрсдийн уламжлан ирсэн зан заншил, түүх соёл, шашин шүтлэгээ дээдлэх нь хязгаарлагдмал байсан. Өнөөдөр хэдийгээр уламжлалт түүхэн соёл, хуучин бүхнээ сэргээх боломжтой болсон боловч дахин өөр хүчин зүйл, асуудлууд тулгарч эхлээд байна. Говь нутагт явагдаж буй эдийн засгийн хөгжил дэвшил нь нутгийн уугуул иргэдэд шинэ боломжуудыг нээж өгөх хэдий ч бидний хамгийн үнэт зүйл болох түүхэн өв соёл маань хадгалагдан, хамгаалагдан, үлдэж байгаа эсэхэд тун болгоомжтой хандах ёстой юм.

Өв гэж юу вэ?

Өв гэдэг бол бид бүхний өнгөрсөн үетэй холбоотой хамгийн чухал зүйл юм. Эдгээрт:

- Археологийн дурсгалт газрууд
- Түүхэн байшин, барилгууд
- Палеонтологийн дурсгалт газрууд зэргийг багтаан авч үзэж болно.

Мөн өв гэдэгт биет өвөөс гадна хүмүүсийг хооронд нь болон үе удамд нь холбож өгч байдаг дараах биет бус өвүүд ч давхар багтана. Үүнд:

- Хэл
- Ёс заншил
- Баяр ёслолууд
- Өвт газрууд
- Нүүдэлчдийн амьдралын хэв маяг зэргийг хамруулан ойлгоно.

Ямар учраас өв чухал вэ?

Бид өөрсдийгөө хүн гэдгээ тодотгохын тулд өв гэсэн ойлголтыг хэрэглэдэг. Энэ нь бидний өнгөрсөн үетэй холбож, өнөөдрийг утгатай болгож, ирээдүйд маань газарчилдаг чухал зүйл гэдгийг хүн бүхэн мэднэ. Өв соёлоо алдах нь тухайн үндэстнийг үнэт зүйлсгүй болгосноор залуучууд нь уламжлалаа умартаж, өвөг дээдэс нь тодорхой үүрэг гүйцэтгэхээ болиу уламжлалт ёс заншил, хэм хэмжээ алдагдаж харин гэмт хэрэг, архидалт, нийгмийн задрал газар авах сөрөг нөлөөтэй билээ.

Уламжлалт өвөө хамгаалж авч үлдэнэ гэдэг нь нийгэм, эдийн засгийн хөгжлөө царцанги байдалд оруулна гэсэн санаа огтхон ч биш юм. Харин ч говь нутгийн эрдэс баялгийн арвин их нөөц нь эдийн засгийн өсөлтийг бий болгон нийгмийн өөрчлөлтийг авч ирэх нь тодорхой билээ. Гэвч эдийн засгийн хөгжлийг даган ирсэн шинэ оршин суугчид өөрсдийн уламжлал, хэл, шашны ёс заншил зэрэг зүйлсээ хамтдаа авч ирэх нь ойлгомжтой юм. Ингэхлээр ийм их хурдацтай хөгжлийн үед уугуул иргэд өөрсдийн уламжлалт ёс заншилаа хэвээр хадгалан үлдэх нь энэ цаг үед тохиолдож буй маргаангүй маш том шалгуур юм.

Бид юу хийж чадах вэ?

Бидэнд маш сайн төлөвлөсөн төлөвлөгөө хэрэгтэй. Ялангуяа эдийн засгийн хөгжилтэй уялдуулан бүс, орон нутаг, улс орны хувьд амин чухал соёлын өвүүдийг хамгаалах Хөтөлбөр бидэнд хэрэгтэй. Монголын Олон Улсын Баг (МОУБ) нь “Оюу Толгой”-н захиалгаар уг Соёлын Өвийн Хөтөлбөрийг боловсруулахаар сонгогдон ажиллаж эхлээд байна. Бид хөтөлбөр боловсруулах ажлын судалгааг гурван гол хэсэгт хуваасан нь биет бус өвийн судалгаа, биет өвийн судалгаа, олон нийтийн хөтөлбөрийн судалгааны ажлууд юм. Эхний 2 хэсгийн тухайд эдгээр нь маш тодорхой биет өв дурсгал, уламжлал ёс заншил зэргийг судалдаг бол гурав дахь судалгааны хэсгийн хувьд соёлын өвийн талаарх ойлголтыг сургууль, музейгээр дамжуулан хүмүүст хэрхэн ойлгуулах боломжтой талаар болон өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх арга замыг судлана.

Бид хэн бэ?

“Монголын Олон Улсын Өвийн Баг” нь “Соёлын Өвийн Хөтөлбөр” боловсруулах чиглэлээр ажиллах Монголын болон олон улсын судлаачдыг нэгтгэсэн баг юм. Төслийн удирдагчаар ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор (Ph), профессор Б. Гүнчинсүрэн ажиллаж байна. Харин, “Биет өвийн дурсгал судлах судалгааны хэсэг”-ийг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Авран хамгаалах археологийн секторын эрхлэгч, доктор (Ph), дэд профессор Ч. Амартүвшин, “Биет бус өвийн дурсгал судлах судалгааны хэсэг”-ийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph), дэд профессор С. Чулуун, “Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны хэсэг”-ийг доктор (Ph), дэд профессор Ж. Гэрэлбадрах нар тэргүүлэн ажиллаж байна.

Таны оролцоо юу байх вэ?

Аль дурсгалууд хамгаалагдах шаардлагатай, шүтлэг бишрэлтэй холбоотойгоор нутгийн ямар хэсгүүдийг, уламжлалыг хамгаалан авч үлдэх нь чухал болох, өв уламжлалаа үр хойчдоо хэрхэн өвлүүлж үлдээх, зааж сургах талаар таны санал манай судлаачдад нэн чухал билээ. Манай баг СӨХ-ийг 2011 оны 7-р сард боловсруулж дуусах ба энэ хугацаанд уг ажлын хүрээнд Өмнөговь аймгийн нутагт төрөл бүрийн уулзалтуудыг зохион байгуулж байна. Энэхүү уулзалтуудад идэвхитэй оролцож, өөрсдийн байр суурийг илэрхийлж, бидэнтэй байнга хамт байхыг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна.

Төслийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй доорх утсаар холбогдоно уу.

Ч.Амартүвшин : 9912 0733

Б.Гүнчинсүрэн : 9905 7280

Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.